БАТЛАВ:
"МОНГОЛЫН ДАЛД УУРХАЙН МУЗЕЙ, СУРГАЛТ СУДАЛГАА, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТӨВ" ТӨСЛИЙН НЭГЖИЙН ЗАХИРАЛ

Н.БАТБОЛД

"МОНГОЛЫН ДАЛД УУРХАЙН МУЗЕЙ, СУРГАЛТ СУДАЛГАА, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТӨВ"-ИЙН МОНГОЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТҮҮХИЙН ТАНХИМЫН ИНТЕРЬЕР ТОХИЖИЛТ, ЗАСЛАЛЫН АЖЛЫН ДААЛГАВАР

2023 оны 01 сарын 06-ны өдөр № 1 Улаанбаатар хот

1	Ажлын үндэслэл	- "Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв" төслийн ТЭЗҮ; - УУХҮ-ийн Сайдын баталсан "Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв" төслийн үзэл баримтлал, Музейн үзүүллэг дэглэлтийн төлөвлөгөө; - "Алтандуулга хаус" ХХК-ийн боловсруулсан интерьер заслалын ажлын зураг төсөл, төсөв. / А/2022-10 дугаартай ажлын зураг, А/17-2022 дугаартай төсөв. ./
2	Захиалагч	УУХҮЯ-ны харьяа "Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв" төслийн нэгж
3	Ажлын байршил	Хэнтий аймаг, Батноров сум, Бэрх хот. Улаанбаатар хотоос 400 км, Чингис хотоос 70 км-т. "Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв" төслийн нэгж
4	Ажлын нэр	""Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв"-ийн газрын гүнд газрын гадаргаас - 45 метрт байрлах музейн үзүүллэгийн танхимын дотоод интерьер тохижилт, заслалын барилга угсралтын ажил. Үүнд: 1.Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв"-ийн Монголын үйлдвэрлэлийн түүхийн танхимын интерьер тохижилт, заслалын ажил.
5	Ажлын зорилго	1.Монголын үйлдвэрлэлийн түүхийн танхимын интерьер тохижилт, заслалын ажил: - Үзүүллэг дэглэлтийн төлөвлөгөөний дагуу танхимын ханыг дуу тусгаарлагчтай ус чийгэнд тэсвэртэй поликорбинат хавтангаар өнгөлөх, төмөр каркас зангидан чийгэнд тэсвэртэй поликорбинат хавтангаар тааз угсрах, шалны цементэн зуурмаг дээр хальтардаггүй хиймэл чулуун хавтанцар наах, хана болон таазанд бэхэлгээний төмөр суулгах, цахилгаан халаалт суурилуулах, ус чийгнээс хамгаалагдсан гэрэлтүүлэгч угсрах, автомат шилэн хаалга хийж, Хавсралт 1-д хавсаргасан тоног төхөөрөмжөөр тоноглон, хаяг, үзмэрийн тайлбар бүхий самбарыг нэг загвараар хийж байрлуулах; 2.Монголын үйлдвэрлэлийн түүхийн танхимын интерьер тохижилт, заслалын ажил, үзүүлбэрүүдийг үзүүллэг дэглэлтийн төлөвлөгөө болон батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгэх;

		- Эдгээр ажлуудыг гүйцэтгэхдээ батлагдсан зураг төслийн дагуу материалын чанарыг анхаарч, төсөвт өөрчлөлт оруулахгүйгээр, захиалагч болон зураг төслийн зохиогчтой зөвшилцөн интерьер-дизайны материалын өнгө, чанарын сонголтуудыг хийж гүйцэтгэх;
6	Гүйцэтгэгчид санал болгох үнэ	Монголын үйлдвэрлэлийн түүхийн танхимын интерьер тохижилт, заслалын ажил-140,105,853.0 / Нэг зуун дөчин сая нэг зуун таван мянга найман зуун тавин гурав / төгрөг;
7	Хөрөнгө оруулалтын хэлбэр	Монголросцветмет ТӨҮГ-ын дүйцэхүйц нөхөн сэргээлтийн санхүүжилт
8	Ерөнхий шаардлага	УУХҮ-ийн Сайдын баталсан "Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв" төслийн үзэл баримтлал, Музейн үзүүллэг дэглэлтийн төлөвлөгөө болон "Алтандуулга хаус" ХХК-ийн боловсруулсан А/2022-10 дугаартай ажлын зураг, А/17-2022 дугаартай төсөвт тусгагдсаны дагуу ажлыг гүйцэтгэх
9	Тендерт оролцогчдод тавигдах шаардлага	- Тендер зарлагдах үед татварын болон НДШ-ийн өргүй байх; - Сүүлийн 2 жилийн аль нэгэнд компанийн борлуулалтын орлого тендерт зарлагдсан төсөвт өртгөөс дээш байх; - Гүйцэтгэсэн ажлын баталгаат хугацаа Барилгын тухай хуульд заасан дагуу зөвшөөрсөн байх; - БУА-н гүйцэтгэгч нь Хөдөлмөрийн Аюулгүй Байдал Эрүүл Ахуйн нөхцөлийг бүрэн хариуцан ажиллана.
10	Онцгой нөхцөл	- MNS 5634:2006 Гар урлал болон урлагийн зориулалт-тай зүйлс. Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага - Барилгын дотор интерьер заслалын ажлын БД,БНбД, MNS, Стандартын дагуу гүйцэтгэх - MNS ASTM C 76:2004 Ус зайлуулах болон ариутгах татуургын төмөр бетон хоолой. - Техникийн шаардлагыг тус тус мөрдөн ажиллах
11	Галын аюулгүй байдлын нөхцөл	"Барилга байгууламжийн галын аюулгүй байдал "БНбД 21-01-02, "Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүй норм" БНбД21-02-02, "Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж дохиоллын хэрэгсэл" БНбД 21-04-05 норм дүрмээс холбогдох заалтуудыг авч төлөвлөнө.
12	Хэрэгжих хугацаа	Гэрээний нөхцлөөр

ТАНИЛЦСАН: ТӨСЛИЙН ЗАХИРАЛ Н.БАТБОЛД

ХЯНАСАН: ТӨСЛИЙН МЕНЕЖЕР М.ОТГОНБЯМБА

БОЛОВСРУУЛСАН:

ТӨСЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖЕР Ш.ЭРДЭНЭЦЭЦЭГ

ТӨСЛИЙН ИНЖЕНЕР Ц.ЗОРИГТ